



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№83 /527/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.05.23

Цаг үе, үйл явдал

“БИДНИЙ БАХАРХАЛ” ТӨСӨЛ БУЛГАН АЙМГИЙН СУМДАД ХЭРЭГЖИЖ БАЙНА



Орон нутагт батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, “Бидний бахархал” төслийг хэрэгжүүлэх арга хэмжээ Булган хот болон Тэшиг, Дашинчилэн, Орхон, Хишиг-Өндөр, Могод сумдад амжилттай өрнөлөө.

Угарга хэмжээний хүрээнд ард иргэдэд батлан хамгаалах бодлого зорилт, үйл ажиллагааны талаарх

мэдээ мэдээллийг хүргэсний зэрэгцээ Батлан хамгаалахын төв архивын ажилчид лавлагаа мэдээлэл, хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн, Цэргийн төв эмнэлгийн эмч мэргэжилтнүүд эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийсэн, ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хэсэгчилсэн тоглолтоо толилуулсан зэргээр хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэв. Мөн ҮБХИС, “Алдар” спорт

хороо, Монгол цэргийн музейн бүрэлдэхүүн байгууллагуудынхаа танилцуулга мэдээллийг хүргэсэн бөгөөд үзэсгэлэн дэлгэж олны хүртээл болгов.

Үүнээс гадна ҮБХИС-ийн ахмад багш нар, БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга хүүхэд залууст цэрэг, эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэхэд

чиглэсэн лекц, яриа таниулгуудыг хийсэн бөгөөд “Энхий үйлсэд 20 жил”, “Тусгаар тогтнолын үнэ цэн” баримтад киног үзэгчдийн хүртээл болгосон юм. Мөн дээрх сумдын ЕБС-ийн сурагчдын дунд 3x3 сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, шалгарсан баг тамирчдад “Шонхор” зусланд амрах эрхийн бичгийг гардуулав.



“MONGOL WARRIOR” БҮХ НИЙТИЙН ГҮЙЛТИЙН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛНА



Олон Улсын Энхийг сахиулагчдын өдөр, Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг үүрэг гүйцэтгэж эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан ажилтан, цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах, хүүхэд залуучуудад цэргийн албаны онцлогийг сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх зорилготой “MONGOL WARRIOR” бүх нийтийн гүйлтийн тэмцээнийг энэ сарын 29 өдрийн 10 цагт Үндэсний

цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулах гэж байна.

Тэмцээнд зөвхөн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд болон харьяа нэгтгэл, анги, байгууллагын ажилтан, алба хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүд баг бүрдүүлэн оролцох юм.

Тэмцээнийг гэр бүлийн гүйлт, бүх нийтийн гүйлт, цэргийн ачаатай гүйлт гэсэн гурван ангиллаар явуулна. Гэр бүлийн гүйлтэд оролцох

баг тус бүр эрэгтэй нэг, эмэгтэй нэг, хүүхэд /10-12 насны/ нэг, нийт гурван хүний бүрэлдэхүүнтэйгээр гурван километр замыг багаараа туулж гүйцэтгэх бөгөөд нэгтгэл, анги, байгууллага тус бүр гурав хүртэлх баг оролцуулж болох аж.

Бүх нийтийн гүйлтийн хувьд нэгтгэл, анги, байгууллага тус бүр нас, хүйс харгалзахгүйгээр бие бүрэлдэхүүнийг хамруулах боломжтой бөгөөд оролцох хүний тоо, зэрэглэлд дээд хязгаар байхгүй. Бүх нийтийн гүйлтэд оролцох тамирчид тав хүртэлх километр замыг туулж барианд орно. Багийн дүнг нэгтгэл, анги, байгууллага тус бүрээс оролцсон нийт бүрэлдэхүүний эхний 20 эрэгтэй, 10 эмэгтэй нийт 30 хүний эзэлсэн байрын нийлбэр дүнгээр тооцож гаргана. Хүний тоо бүрдээгүй тохиолдолд гүйлтэд оролцсон тамирчдын эзэлсэн байр амжилтаас үл хамааран сүүлийн байр эзлүүлэх юм.

“Монгол дайчин” гүйлтэд оролцох баг, тамирчид цэргийн хувцастай, 10 килограмм ачаатайгаар эрэгтэй 15 километр, эмэгтэй 10 километр замыг туулах ба нэгтгэл, анги, байгууллага тус бүрээс найман эрэгтэй, хоёр эмэгтэй хүний бүрэлдэхүүнтэй нэг баг оролцуулах юм.

Тамирчид өөрийн байгууллагын дүрэмд заагдсан хээрийн хувцас, саравчтай малгай,

хагас түрийтэй гуталтай, цэргийн зориулалттай аранзтай байх ба аранзанд байх ачааны эд зүйлийг заагдсан жинд тохируулан өөрийн сонголтоор бүрдүүлнэ. Тамирчин барианд малгайгүй орвол нэг байр, гээгдүүлсэн бол таван байр, ачаагүй орсон тохиолдолд 10 байр ухрааж дүгнэх ба хүн дутуу гарсан, гараад барианд ороогүй тохиолдолд хамгийн сүүлийн байр эзлүүлэх аж.

Тэмцээний шаардлага:

1. Тэмцээний гэр бүлийн болон бүх нийтийн гүйлтэд оролцох баг тамирчид спортын хувцсаар жигдэрсэн байна.
 2. Баг, тамирчид байгууллагын хаяг, тугтай байна
 3. 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр ЗХЖШ-ын 320 тоотод хүрэлцэн ирж техникийн зөвлөгөөнд хамрагдсан байх
 4. Байгууллагын эмч тэмцээнд оролцох баг тамирчдын эрүүл мэндийн тодорхойлолтыг гаргаж шүүгчдийн бүрэлдэхүүнд өгөх
 5. Тамирчид гүйлт эхлэхийн өмнө иргэний үнэмлэх, байгууллагын нэвтрэх үнэмлэхийг авч ирэн бүртгэлд хамрагдана.
- Тэмцээнд амжилт гаргасан баг тамирчдыг Монгол цэргийн нэгдсэн холбоо, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулах ажээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	🌧️ 6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,450	3,455
EUR 🇪🇺	3,740	3,765
CNY 🇨🇳	492.50	494
RUB 🇷🇺	43.10	43.40
JPY 🇯🇵	25,20	25.55
KRW 🇰🇷	2.62	2.63

ЗУРХАЙ

2023.05.23 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

ЗУНЫ ТЭРГҮҮН УААГЧИН МОГОЙ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.05-20.33
Барилдлага:
Хүчин төгсөх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Хурьцахуй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 689,046,272

Эдгэрсэн

Нийт: 661,440,310

Нас барсан

Нийт: 6,880,725

Цахим шууданд

“ЭНХИЙГ ДЭМЖИГЧ МОНГОЛ УЛС” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА



Бүгд Найрамдах Ирак Улс, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсаас цэргийн баг оролцуулсны 20 жилийн ойг тохиолдуулан цэргийн багуудын туршлага, сургамжийг судалж, улс төр, нийгэм эдийн засгийн ач холбогдлыг нарийвчлан тодорхойлох зорилгоор “Энхийг дэмжигч Монгол Улс” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг энэ сарын 25-ны өдөр зохион байгуулах гэж байна.

Эрдэм шинжилгээний хурлыг ҮБХИС-ын “Сүбээдэй” хуралдааны танхимд зохион байгуулах ба ҮАБЗ-ийн ажлын алба, ЕТГ, БХЯ, ГХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн байгууллагууд, ҮАБЗ-ийн Стратегийн судалгааны болон Аюулгүй байдал, судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид оролцох юм.

“ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР...



командлалын штабын дарга, бригадын генерал Б.Эрдэнэбат “Энхийг дэмжих ажиллагааны бодлого, цаашдын чиг хандлага” сэдвээр тус тус мэдээлэл хийсэн юм.

Хэлэлцүүлэгт энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багийн захирагчаар болон цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн туршлагатай энхийг сахиулагч офицер, ахлагч нар оролцож энхийг дэмжих ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга зам, боломжийн талаар санал солилцож, энхийг дэмжих ажиллагааны цаашдын чиг хандлага, түүнд Монгол цэргийн оролцооны талаар мэтгэлцлээ.

Зохион байгуулагчдын зүгээс хэлэлцүүлгээс гарсан саналд дүн шинжилгээ хийн, зөвлөмж боловсруулж, салбарын удирдах бүрэлдэхүүнд хүргүүлэн, энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын цар хүрээг өргөжүүлэхээр боллоо.

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 45 жилийн ой, Олон улсын энхийг сахиулагчдын өдрийг угтаж тус хүрээлэнгийн Энхийг дэмжих олон улсын судалгааны төвөөс “Энхийг дэмжих ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Арга хэмжээнд НҮБ-ийн суурин зохицуулагчийн газрын Хүний эрхийн үндэсний зөвлөх Ч.Алтангэрэл “НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, сайн туршлага”, Агаарын цэргийн

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



хамрагдаж, сургалтыг НЗДТГ-ын Цэргийн штабын хуулийн баг, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын сургалтын бүлэгтэй хамтран зохион байгууллаа.

Сургалт-дадлагад дүүргийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах товчооны дарга бэлтгэл дэд хурандаа С. Даваасүрэн, Багануур дүүргийн ЗДТГ-ын цэргийн штабын дарга, Батлан хамгаалах товчооны нарийн бичгийн дарга Хурандаа З.Майдар, ЗДТГ-ын дарга, бэлтгэл дэслэгч П.Баттүшиг нар оролцож, Батлан хамгаалахын багц хуулиуд болон Орон нутгийн хамгаалалтын тухай хуулиар онолын мэдлэг олгосноос гадна практик дадлага олгосон юм.

Сургалтын төгсгөлд Үндсэн хуулиар хүлээсэн Иргэний үүргээ ёсчлон биелүүлж, зарлан дуудах мэдэгдлээр хүрэлцэн ирсэн бэлтгэл үүрэгтнүүддээ талархал илэрхийлж, СЕРТИФИКАТ гардуулснаар сургалт-дадлага өндөрлөв.

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

Багануур дүүрэгт хамгаалалтын нөөц бүрдүүлэлтэд анх удаагаа “Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж”-ийн сургалт дадлагыг зохион байгууллаа. Дүүргийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах товчооны дарга С.Даваасүрэн сургалтыг нээж хэлэн үгэндээ Дайчилгаа, Орон нутгийн

Энэхүү сургалтад бэлтгэл офицер, ахлагч, нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүд

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 189 ДҮГЭЭР АНГИ 3000 ШИРХЭГ БУРГАСНЫ ТАРЬЦЫГ СУУЛГАЛАА



Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн гэр бүлийн хамтаар “Эх дэлхийгээ хайрлая” уриан дор нэгдэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нэгдлээ.

Энэ хүрээнд Дархан цаазат Богд хан уулын “Харганат”-ын аманд байрлах Улаанбаатар 4

Хошууч Ц.ЦЭВЭГДОРЖ

Дарга дэд хурандаа
САЙНБОЛДЫН
УУГАНБААР

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний
Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” редакц
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН “АВЛИГА, АВЛИГЫН ШАЛТГААН НӨХЦӨЛ” СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Монгол Улсын Засгийн газрын “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоол болон Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Батлан хамгаалах яамны 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажил, арга хэмжээний хүрээнд Цэргийн төв эмнэлгийн сувилагч нарт “Авлига, авлигын шалтгаан нөхцөл”

сэдвээр Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн шинжээч Л.Ганзориг сургалт зохион байгуулав. Сургалтаар Авлига гэж юу бэ, авлигын хор уршиг, авлига үүсэх шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох мэдээллийг өгч, эрх зүйн орчин, зохицуулалтын талаарх ойлголтыг өгсөн юм.

БХЯ

“ЗАЛУУ ҮЕ-ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 150 дугаар анги

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын чуулга” уулзалтыг угтан “ЗАЛУУ ҮЕ- ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Энэ хүрээнд соёл хүмүүжлийн офицер ахмад Н.Дэлгэрмаагаар ахлуулсан сургалтын бүлэг 6 офицерын бүрэлдэхүүнтэйгээр

Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын 13 сургуулийн 1300 орчим ахлах болон дунд ангийн сурагчдад батлан хамгаалах бодлого зорилтыг сурталчлан таниулах арга хэмжээг 3 хоногийн хугацаанд зохион байгуулав. Сургалтаар сурагчдад эх орны ирээдүй болсон залуу хойч үе ямар байх ёстой талаар харилцан ярилцаж хэлэлцүүлэг хийж оновчтой санал, санаачилга гаргасан сурагчдыг урамшуулсан юм.

СУРАГЧИД ЭХ ОРОНЧ ҮЗЛЭЭР СУРГАЛТ ЯВУУЛСАНД ОЛЗУУРХАЖ БАЙВ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицерууд”-ын чуулга уулзалтыг угтаж Хөвсгөл аймгийн “Эрдмийн далай” ерөнхий боловсролын дунд сургуулийн Ц.Оюунгэрэл багштай 116 ангийн 35 сурагчдад цэрэг-эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор

“Залуу үе-Эх орны ирээдүй” сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг ангийн байрлалд 5 дугаар сарын 22-ны өдөр явууллаа.

Тус арга хэмжээний үеэр зэвсэглэл, химийн багаж хэрэгслийг дэлгэн, гардан тулааны үзүүлэх тоглолтыг өргөн барьсанд сурагчид сэтгэл өндөр байж хугацаат цэргийн алба хаагчдад өөрсдийн бэлтгэсэн бүжгийн үзүүлбэрээ үзүүллээ.

Сурагчид өөрийн мэргэжлээ сонгоход энэхүү арга хэмжээ нөлөөлсөн, эх орноо хайрлах сэтгэгдлээр дүүрэн байгаагаа илэрхийлж байсан юм.